

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 10

Төрийн ордон, Улаанбаатар хот


**ХӨШИГИЙН ХӨНДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС БАЙГУУЛАХ
ТУХАЙ**

Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас
ТОГТООХ нь:

1.Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх "Чингис хаан" Олон улсын шинэ нисэх буудлыг
түшиглэн "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс" байгуулсугай.

2.Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн газрын талбайн хэмжээг 1000 га-аар тогтоож,
газрын байршил, хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

"Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.7, Чөлөөт бүсийн тухайн хуулийн 24.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2. "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах, барилга байгууламжийг барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн захирагчийн ажлын албаны бүтэц, орон тоо, зардлын хязгаарын төслийг боловсруулж, 2025 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ж.БАТСУУРЬ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

"Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн
Захирагчийн ажлын албаны бүтэц, орон
тооны хязгаар батлах тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн, "Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны бүтцийг доор дурдсанаар баталсугай:

1/Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтэс;

2/Захиргаа, санхүүгийн хэлтэс;

3/Дэд бүтэц, газар зохион байгуулалтын хэлтэс;

4/Инновац, технологийн хэлтэс;

5/Хуулийн хэлтэс.

2."Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 30 байхаар тогтоосугай.

3."Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс"-ийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд Б.Жавхлан нарт, чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН